

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ЗОХИОН
БАЙГУУЛСАН АЖЛЫН 2020 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 3 дугаар улирлын байдлаар нийт 18 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч түүний 17 өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

Өргөдөл, гомдлын дэлгэрэнгүй тайлангийн хувьд авч үзвэл:

- Хугацаандаа шийдвэрлэсэн: 16
- Судалж байгаа төлөвтэй: 1
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн: 1 үзүүлэлттэй байна.

Үүнээс:

- Гомдол: 5
- Хүсэлт: 13 /чиг үүргийн холбогдолгүй тул буцаасан өргөдөл, гомдол 1/
- Санал: 1

Өргөдөл, гомдлын хандалтын тайлангийн хувьд авч үзвэл:

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Ажлаас чөлөөлөгдөх тухай	2	11,3%
2	Хүүхэд асрах чөлөө хүсэх тухай	1	5,5%
3	Ажилд орох тухай	1	5,5%
4	Зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагааны тухай	14	77,7 %
Нийт өргөдөл, гомдлын дүн		18	100%

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлангийн хувьд авч үзвэл:

2020 оны 3 дугаар улирлын байдлаар байгууллагад ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 14 хоног 3 цаг 52 минут байна. Энэ хугацаанд тус газар хандаж гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудад хариуг албан бичиг болон утсаар мэдэгдэж 100% барагдуулав.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар газрын дарга болон захиргааны хэлтсийн даргад тухай бүр танилцуулан ажиллаж байна. Газрын хурлаар танилцуулж, НЗДТГ-ын Үйлчилгээний Нэгдсэн төвд улирал бүр өргөдөл, гомдлын тайланг хугацаанд нь хүргүүлж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн зөрчлийн хувьд авч үзвэл:

2020 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 13 зөрчил гарсан байна. Үүнд:

- Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчлийн тоо: 10
- Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо: 3 үзүүлэлттэй байна.

Зөрчлийг гаргасан албан хаагчдад тухай бүр сануулж, сар бүр газрын болон хэлтсийн даргад танилцуулж зохих арга хэмжээг авч ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА



С.БАТБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

A handwritten signature in black ink, likely belonging to R. Batnyam.

Р.БАТНЯМ

ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ

A handwritten signature in black ink, likely belonging to T. Tuul.

Т.ТУУЛ